



Европын Холбоо  
Санхүүжүүлэв




Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



# ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД  
ЗОРИУЛСАН СУРГАЛТ

## СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ  
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ  
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

Төсвийн ил тод байдлыг хангах, хариуцлагыг нэмэгдүүлэх, ИНБ-д төсвийн шинжилгээ, хяналт хийхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Европын Холбооны санхүүжилттэй хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав.

#### Ерөнхий зүйл:

Энэхүү тайлан нь Европын холбоо (EX)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд EX болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. EX, НҮБХХ энэхүү тайланда гарсан тоо баримтын үнэн зөв эсэхийг баталгаажулахгүй бөгөөд тоо баримтыг ашигласнаар гарах үр дагаврыг хариуцахгүй. НҮБХХ-өөс зохих ёсны зөвшөөрөл авсан тохиолдолд тус судалгаа, тайланг хувийн болон арилжааны бус зорилгоор хэвлэх эсвэл хуулбарлахыг зөвшөөрнө. НҮБХХ-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор худалдах, түгээх, дуурайлган хэвлэхийг хориглоно.

#### ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА



Бэлтгэсэн:

Ц.Болормаа (PhD), МУИС-ийн ХАССТ-ийн захирал  
Ө.Гэрэлт-Од (PhD), МУИС-ийн ХАССТ-ийн судлаач  
Д.Тунгалаг, МУИС-ийн ХАССТ-ийн судлаач  
Т.Хишигдулам, МУИС-ийн ХАССТ-ийн судлаач

Монгол Улсын Их Сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв  
МУИС-ийн байр #5, Өрөө 508; 510  
Бага тойруу-7, Сүхбаатар дүүрэг  
Шуудангарын хайрцаг 46а/301  
Улаанбаатар хот, Монгол Улс  
Утас: +976 7575 4400 (2304) Мэйл: [boogiits@gmail.com](mailto:boogiits@gmail.com)

© 2021 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр  
Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын тэргүүлэх агентлаг юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дунд эх дэлхий, хүн бүрийн төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Та дараах хаягаар орж танилцах боломжтой: <http://mn.undp.org>

Та бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу:  
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр  
НҮБ-ын Байр, Нэгдсэн Үндэстний Гудамж -14  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201  
Монгол Улс  
Утас: + 976-11-327585



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



# ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД  
ЗОРИУЛСАН СУРГАЛТ

СУРГАГЧ БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

2022 оны 1-р сар

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	04
ОРШИЛ	05
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	09
ТАНИЛЦУУЛГА	10
Сургалтын зорилго	
Сургалтын зохион байгуулалт	
МОДУЛЬ НЭГ: ТӨСВИЙН ТУХАЙ	11
Хичээл 1:     Төсвийн тухай ойлголт, төсвийн бүрэлдэхүүн	11
Төсвийн үйл явц, цаглабар	
Дасгал ажил	
Хичээл 2:     Төсвийн мэдээ, мэдээлэл, тайлан	12
Төсвийн үндсэн баримт бичиг, тайлангууд	
Дасгал ажил	
МОДУЛЬ ХОЁР: ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОГЧ ТАЛУУД	14
Хичээл 3:     Төсвийн үйл явцад иргэн, ИНБ-ын	14
оролцооны төрөл хэлбэр, оролцоот төсвийн	
онцлог	
Ярилцлагын асуултууд	16
МОДУЛЬ ГУРАВ: ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ	19
Хичээл 4:     Төсвийн шинжилгээний зорилго, ач холбогдол	19
Төсвийн шинжилгээ хийх арга зүй	
Дасгал ажил	

Хичээл 5:	Төсвийн хяналтын зорилго, ач холбогдол Төсвийн хяналт хийх арга зүй Дасгал ажил	34
<b>МОДУЛЬ ДӨРӨВ: ТӨСВИЙН СУРТАЛ, ТАНИУЛГА</b>		38
Хичээл 6:	Төсвийн сурталчилгаа, нөлөөллийн зорилго, ач холбогдол Төсвийн сурталчилгаа, нөлөөлөл явуулах арга зүй Дасгал ажил	38
<b>СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС</b>		39
<b>НОМ ЗҮЙ</b>		42
<b>ХАВСРАЛТ: Power Point танилцуулга материал</b>		

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИС	Монгол улсын их сургууль
ННФ	Нээлттэй нийгэм форум
НУБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОНХС	Олон нийтийн хөгжлийн сан
ОУВС	Олон улсын валютын сан
ОУТТ	Олон улсын төсвийн түншлэл
ОУТХАБ	Олон улсын төсвийн хамтын ажиллагааны байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТИТБОУС	Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга
TX3	Тогтвортой хөгжлийн зорилтууд
УИХ	Улсын их хурал
ХАССТ	Хүн амын сургалт судалгааны төв
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага

## ОРШИЛ

НҮБ-аас дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-д эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох, тэгш бус байдлыг бууруулах, хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэхээр тусгасан. Эдгээр заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, НҮБХХ-ийн “ТХЗ-уудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс улсын төсөвт оролцогч талуудын хариуцлага, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэд, ИНБ-уудын төсөвт шинжилгээ, хяналт хийх ур чадварыг сайжруулах ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж байна. Тус төслийн төлөвлөгөөт үйл ажиллагааны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулах СУРГАЛТ-ын үйл ажиллагаа багтаж байна.

Энэхүү сургалтын агуулгыг төсвийн сахилга бат, хариуцлагын талаар Монгол Улсын баримталж буй бодлого хөтөлбөр, эрхэйн зохицуулалт, гүйцэтгэх засаглалын санхүүгийн хэтийн зорилго, хүлээгдэж буй үр дүн болон төсвийн гүйцэтгэлийг хянахад олон нийтийн оролцоо, талуудын ойлголцол, хүчин чармайлтын учир дутагдалтай байдалд дүгнэлт хийсэн шинжилгээг үндэслэн боловсруулсан.

Төсвийг хариуцлагатай бүрдүүлэх, зарцуулах, өөрөөр хэлбэл, төсвийн сахилга бат сахиулах үйл ажиллагаа нь дан төрийн байгууллагын үүрэг биш. Үүнд татвар төлөгчдийн, хөндрүүгийн хяналтын оролцоог нэмэгдүүлэх шаардлага нэгэнт бий болжээ. Төсвийн хяналт шинжилгээг бодит баримт, баталгаат эх сурвалжид үндэслэн ул суурьтай, мэргэжлийн түвшинд гүйцэтгэх нь талуудын харилцан итгэлцэл, түншлэлийг өдөөх үүсвэр болно.

Дэлхий нийт болон Монгол Улсын хэмжээнд тархсан Ковид 19 цар тахлын онцгой нөхцөлд зохицуулан тус сургалтыг цахим технологийн дэвшил ашиглан онлайнаар явуулж байгаа нь мэдээллийг орон даяар түгээх цаашлаад хэрэгцээт үед дахин ашиглах боломж бүрдүүлж буйгаараа онцлог юм.

ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ сургалтын сургагч багш нарт зориулсан гарын авлагад хоёр өдрийн, нийт дөрвөн модулийн зургаан хичээлийн агуулга, хичээл тус бүрийн PowerPoint танилцуулга материал, ярилцлагын асуулт, сэдэв тус бүрийн дасгал ажлууд багтсан. Модуль тус бүрийн хичээлийн агуулгыг ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ: ИРГЭД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА-тай нягт уялдуулан боловсруулсан тул хамт ашиглахыг зөвлөж байна.

## Сургалтад мөрдөх зарчим

**Хандлага:** Төсвийн хяналт, шинжилгээ сургалт нь оролцооны аргаар буюу оролцож сурах зарчим, арга барилд дээр суурилсан. Сурах үйл явц нь өөрийн өмнөх мэдлэг, чадварт тулгуурлан шинэ мэдлэг, чадвар эзэмших, суралцах явцад ойлголтоо нягтлах, батжуулах боломжоор хангагдсан.

Сургагч багш нар:

- Оролцогчдын тэгш, идэвхтэй оролцоог хангана.
- Оролцогчдыг бүлгээр ажиллуулахдаа хүйсийн тэгш байдлыг хангана.
- Оролцоог тэгш, хүртээмжтэй байлгах зорилгоор нэг нутаг, байгууллагын хүмүүсийг салгаж өөр бүлэгт хуваарилж ажиллуулна.
- Оролцогчдыг багт хуваахдаа аль болох өөр өөр мэргэжлийн хүмүүсээр багийг бүрдүүлнэ.
- Оролцогчдын өмнөх мэдлэг, чадвар, туршлагыг сургалтын агуулгад тусгаж өгөхийг хичээнэ.
- Шинэ мэдлэг, ойлголтыг ямагт практик туршлагаар баяжуулна.
- Сургалтын явцад оролцогчдод дасгал ажил хийх цагийг хангалттай олгож мэдлэгийг батжуулахыг чармайна. Мэдлэгийг биежүүлж, эзэнтэй болгох нь чухал. Сурах үйл явц нь ойлгох, ойлгосноо батжуулах, өөрийн болгох эрэмбэтэйг сана.
- Сургалтын явцад албан бус, шууд бус аргаар, жишээ нь тоглоом тоглонгоо сурах аргыг хэрэглэхийг оролдоно. Мөн тоглоомыг оролцогчдыг идэвхижүүлэх зорилгоор хөнгөхөн сэргээш байдлаар ашиглаж болно.
- Сургалтын агуулга, мэдээлэл оролцогчдод шинэ тутам байх тул тэдний ойлголт, шингээлтийн түвшинд тохируулан сургагч багш өөрчлөлт хийж болно.

**Сургагч багш нар:** Төсвийн хяналт, шинжилгээ сургалтыг сургагч багш нар багаар заахаар зохион байгуулсан. Төслийн хүрээнд олгогдсон хугацааны дагуу хоёр өдөрт багтаан 4 модулийн б хичээл байхаар төлөвлөсөн. Хичээл бүрт хоёр сургагч байх ба нэг багш туслах, чиглүүлэх, нөгөө нь үндсэн хичээлээ заах үүрэгтэй оролцено.

**Үнэлгээ:** Сургалтын агуулга, заах арга, ойлголтыг хичээл бүрээр албан бус байдлаар лавлаж тодруулна. Нийт оролцогчдын дунд асуулт тавих эсвэл хичээлийн дараа оролцогчдоос сонгон албан бус байдлаар тандалт

явуулж болно. Үүнийг үндэслэн шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж болно. Сургалтын төгсгөлд албан ёсоор үнэлгээний асуулга бөглүүлнэ.

**Идэвх, оролцоо:** Хоёр өдрийн сургалт нь маш богино хугацаанд их хэмжээний мэдээлэл өгч буй сургалт учраас оролцогчдын анхаарлыг сургуулахгүй байхад гойд анхаарах шаардлагатай. Оролцогчид хэт их мэдээлэл, уртасгасан цагийн хичээл, үл мэдэх байдлаасаа болж залхахыг үгүйсгэхгүй. Тийм учраас оролцогчдын идэвх буурч, анхаарал сарних үед идэвхжүүлэх, сэргээх завсарлага өгөх эсвэл тоглоом тоглуулах зэргээр тэдэнтэй ажиллана.

Оролцогчид ядарсан үед:

- Ширээн дээр гарaa дэрлэн 2 минут амрах,
- Нүдээ аниад 1 минут чимээгүй, хөдөлгөөнгүй суух Г.М аргыг хэрэглэх.

Оролцогчдын бие хөшсөн бол:

- Энгийн 8 тоот дасгалаар оролцогчдын гар хөлийг хөдөлгөж, чилээг гаргах,
- Оролцогчид босоод, хоорондоо ярихгүйгээр өрөөгөө тойрч алхах Г.М аргыг хэрэглэх.

Оролцогчдын тархи цуцсан бол:

- 2 минут завсарлага өгөх,
- Хичээлийн сэдвээр өөр зүйлээр 5 минут ярих Г.М аргыг хэрэглэх.

### Оролцогчдыг идэвхжүүлэх хөнгөн тоглоомын санаанууд

**Тоглоом 1.** Оролцогчид цуцсан ямар ч үед хэрэглэх боломжтой. Ямар нэг зүйлийг (талх, ундаа, цэвэр ус Г.М) сонгоод оролцогч тус бүрээс ямар үнээр худалдаж авдгийг асуух. Дараа нь яагаад тэдний худалдан авдаг үнэ зөрүүтэй байгааг лавла.

**Тоглоом 2.** Оролцогчдыг 10-10-аар баг болгож 1-10 тоог бусдад мэдэгдэхгүйгээр онооно. Тэгээд багийн гишүүд ээлж ээлжээр сонгосон хүнийхээ тоог таахыг оролдоно.

**Тоглоом 3.** Оролцогчдыг бүлэг болгон ангилах.

- Хүйс (эр, эм)
- Дуртай өнгө (дурын өнгө нэрлэх)
- Хобби
- Мэргэжил (нягтлан бодогч, хуульч Г.М)-ээр дуудаж гар өргүүлэн ижилсүүлэн, ангилна.

**Тоглоом 4.** Үгэн тоглоом. Зохион байгуулагч нэг үсэг нэрлэхэд оролцогчид ээлж ээлжээр тэр үсгээр эхэлсэн төсөв, санхүү, хяналт шинжилгээтэй холбоотой үг хэлнэ. Жишээ нь А - аудит Г.М.

## Бэлтгэл ажил

- Сургалт эхлэхээс өмнө оролцогчдыг бүртгэлжүүлэн, онлайн сургалтанд хамрагдах нөхцөл, чадамжийг тодруулсан байна.
- Оролцогчдад гарын авлага болон жишээ татах файл, сургалтын материалыг урьдчилан бүртгэлтэй и-мэйл хаягаар нь түгээсэн байна.

Сургалт эхлэхээс өмнө оролцогчдод техникийн зааварчилгаа өгч болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлнэ.

### Сургалтад ашиглах материал, хэрэгслийн жагсаалт:

- Сургалтад оролцогчдын танилцуулга PDF файлаар
- Сургалтын хөтөлбөр PDF файлаар
- Төсвийн хяналт, шинжилгээ: ИНБ-уудад зориулсан гарын авлага PDFфайлаар
- Хичээл бүрээр бэлтгэсэн PPT слайдууд
- Сургалтын хүлээлт, үнэлгээний хуудас
- Даасгал ажлын хуудас Word Doc файлаар
- Монгол Улсын төсвийн үндсэн баримт бичгүүдийг PDF файлаар
- 20XX оны улсын төсвийг PDF файлаар
- Компьютер
- Проектор
- Цагаан самбар, маркер

# СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

	Сэдэв	Эхлэх цаг	Дуусах цаг	Нийт хугацаа
	Сургалтын нээлт <b>ТАНИЛЦУУЛГА</b>	09:00	09:05	05 мин
	Сургалтад оролцогчид танилцах			
	Сургалтын зорилго	09:05	09:40	35 мин
	Сургалтын зохион байгуулалт			
	Оролцогчдоор хүлээлтийн асуулга бөглүүлэх			
	<b>МОДУЛЬ 1: ТӨСВИЙН ТУХАЙ</b>			
	<b>Хичээл 1:</b>			
	Төсвийн тухай ойлголт, төсвийн бүрэлдэхүүн	09:40	10:20	40 мин
	Төсвийн үе шат, цаглабар			
	Дасгал ажил			
	<b>Хичээл 2:</b>			
	Төсвийн мэдээ, мэдээлэл	10:20	11:10	50 мин
	Төсвийн үндсэн баримт бичиг, тайлангууд			
	Дасгал ажил			
	<b>Цайны завсарлага</b>	11:10	11:30	15 -20 мин
	<b>МОДУЛЬ 2: ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОГЧ ТАЛУУД</b>			
	<b>Хичээл 3:</b>			
	Төсвийн үйл явцад иргэн, ИНБ-ын оролцооны төрөл	11:30	12:30	60 мин
	хэлбэр, оролцоот төсвийн онцлог			
	Төсвийн үйл явцад оролцсон туршлага хуваалцах			
	<b>Өдрийн завсарлага</b>	12:30	13:30	60 мин
	<b>МОДУЛЬ 3: ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ</b>			
	<b>Хичээл 4:</b>			
	Төсвийн шинжилгээний зорилго, ач холбогдол	13:30	15:00	90 мин
	Төсвийн шинжилгээ хийх арга зүй			
	Дасгал ажил			
	<b>Цайны завсарлага</b>	15:00	15:15	15 мин
	<b>Хичээл 4:</b>			
	Төсвийн орлогын шинжилгээ	15:15	16:45	90 мин
	Дасгал ажил			
	<b>Хичээл 4:</b>			
	Төсвийн зардал, санхүүжилт, хуваарилалтад хийх	09:00	10:30	90 мин
	шинжилгээ			
	Дасгал ажил			
	<b>Цайны завсарлага</b>	10:30	10:45	15 мин
	<b>Хичээл 5:</b>			
	Төсвийн хяналтын зорилго, ач холбогдол	10:45	12:15	90 мин
	Төсвийн хяналт хийх арга зүй			
	Дасгал ажил			
	<b>МОДУЛЬ 4: ТӨСВИЙН СУРТАЛ, ТАНИУЛГА</b>			
	<b>Хичээл 6:</b>			
	Төсвийн сурталчилгаа, нөлөөллийн зорилго, ач холбогдол	12:15	13:15	60 мин
	Төсвийн сурталчилгаа, нөлөөлөл явуулах арга зүй			
	Дасгал ажил			
	<b>СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ</b>	13:15	13:30	15 мин
	Сургалтын хаалт	13:30	13:45	15 мин

## ТАНИЛЦУУЛГА

Хугацаа: нийт 35 минут

**Зорилго:** Сургалтын зохион байгуулагчид, оролцогчид бие биетэйгээ танилцаж, нүүр хагарахаас гадна сургалтын зорилго, сургалтын хөтөлбөр, цагийн хуваарь, зохион байгуулалтын талаар мэдээлэл авна.

- |    |   |          |
|----|---|----------|
| 1. | Сургалтад оролцогч талуудын танилцуулга | 15 минут |
| 2. | Сургалтын зорилго                       | 5 минут  |
| 3. | Сургалтын зохион байгуулалтын асуудлууд | 10 минут |
| 4. | Оролцогчдын хүлээлтийн асуулга хуудас   | 5 минут  |

### 1 Сургалтад оролцогчдын танилцуулга

Сургагч багш нар, сургалтад оролцогч тус бүрийн товч танилцуулгыг 1 ppt-хуудсанд багтаан бэлтгэсэн байна. Үүнд:

- Овог нэр
- Байгууллагын нэр
- Албан тушаал
- Төсвийн хяналт, шинжилгээний талаар туршлагатай эсэх
- Ижил төстэй сургалтад хамрагдаж байсан эсэх.

### 2 Сургалтын зорилго

Сургалт зохион байгуулагчид энэхүү сургалтын зорилго, төсвийн хяналт, шинжилгээний ур чадвар эзэмшихийн ач холбогдолын тухай товч танилцуулна.

### 3 Сургалтын зохион байгуулалт

Сургалт зохион байгуулагчид

- Сургалтын хөтөлбөр, цагийн төлөвлөлтийг танилцуулна.
- Урьдчилан илгээсэн сургалтад ашиглагдах гарын авлага, бусад материалын тухай товч танилцуулна

### 4 Оролцогчдын хүлээлт, үнэлгээний асуулга хуудас

Сургалт зохион байгуулагчид

- Оролцогчдоос сургалтаар олж авах мэдлэг, мэдээлэл, сургалтын зохион байгуулалт, арга зүй, хөтөлбөрийн агуулга, ач холбогдол талаар үнэлгээ авах асуулгын танилцуулга хийнэ.

## РРТ СЛАЙДУУД:

- Хавсралт 1-ын Слайд 1-5.

## Модуль нэг: ТӨСВИЙН ТУХАЙ

Нийт: 90 минут

Энэхүү модуль нь хоёр хичээлээс бүрдэх ба төсвийн тухай үндсэн ойлголт, төсөвт хамаарах баримт, бичгийн агуулга, хуулийн болон хугацааны зохицуулалт, шалгуур үзүүлэлтийн талаар ойлголт, мэдээлэл өгөх зорилготой.

### ХИЧЭЭЛ 1:

Хугацаа 40 минут

Агуулга	Төсвийн тухай үндсэн ойлголт өгнө. Үүнд төсөв, төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд, төсвийн үе шат, хугацааны талаарх мэдээлэл багтана.
Төсөв, төсвийн бүрэлдэхүүн	15 минут
Төсвийн үе шат, цаглабар	15 минут
Дасгал 1-1	10 минут

### АШИГЛАХ МАТЕРИАЛ:

- Төсвийн хяналт, шинжилгээ: ИНБ-уудад зориулсан гарын авлагын 6-8 дугаар хуудасны мэдээллийг ашиглах.

### PPT СЛАЙДУУД:

- Хавсралт 2-ын Слайд 1-20.

### ДАСГАЛ 1-1:

Төсвийн үндсэн баримтуудын нэр, тодорхойлолтыг нийцүүлэн, холбох.

Д/д	Төсвийн үндсэн баримт бичиг	Тодорхойлолт
1	Төсвийн хүрээний мэдэгдэл	Ирэх санхүүгийн жилийн параметрүүдийг ил болгосон гүйцэтгэх засаглалын төсөв боловсруулалтын анхан шатны баримт бичиг.
2	Гүйцэтгэх засаглалын төсвийн төсөл	Төсвийн хууль батлагдахаас өмнө олон нийтэд ил болгодог баримт.

3	Батлагдсан төсөв	Хуулиар баталгаажсан ирэх санхүүгийн жилийн төсвийн баримт бичиг.
4	Иргэдийн төсөв	Төсвийн үг хэллэг, үндсэн ойлголтыг мэргэжлийн бус хүмүүст техникийн бус хэлээр ойлгомжтой байдлаар тайлбарласан баримт бичиг.
5	Жилийн явцын тайлангууд	Төсвийн гүйцэтгэлийг сар, улирлаар тайлагнадаг баримт.
6	Хагас жилийн тойм	Төсвийн хэрэгжилттэй холбоотой эдийн засгийн таамгууд, тухайн төсвийн жилийн үр дүнгийн таамгууд зэрэг төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан баримт.
7	Жилийн эцсийн тайлан	Засгийн газрын санхүүгийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг үзүүлсэн баримт бичиг.
8	Аудитын тайлан	Улсын нөөцийг үр дүнтэй ашигласан эсэхийг шалгасан баримт.

Жич: Дасгал ажиллуулахаас өмнө оролцогчдыг бүлэг болгон хуваана. Баримтын нэр, тодорхойлолтыг зөв нийцүүлэн, холбохыг багувд эрмэлзэх ёстой.

## ХИЧЭЭЛ 2:

Хугацаа	50 минут
Агуулга	Төсвийн баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх сурвалжууд, төрөл, хэлбэр, төсвийн үндсэн баримт бичгүүдийн зорилго, агуулга, тэдгээрийн эрхэүйн зохицуулалт, шалгуур үзүүлэлтүүд, ач холбогдолтой танилцана.
Төсвийн мэдээ, мэдээлэл	15 минут
Дасгал 2-1	5 минут
Төсвийн үндсэн баримт бичиг	15 минут
Дасгал 2-2, 2-3	15 минут

## АШИГЛАХ МАТЕРИАЛ:

- Төсвийн хяналт, шинжилгээ: ИНБ-уудад зориулсан гарын авлагын 8-14 болон 32-40 дугаар хуудаст өгөгдсөн мэдээллийг ашиглах.
- Монгол Улсын төсвийн үндсэн баримтаас жишиглэн PDF файлаар урьдчилан түгээсэн байх.

## PPT СЛАЙДУУД:

- Хавсралт 2-ын Слайд 21-37.

## ДАСГАЛ 2-1:

Төсвийн үндсэн баримтын олдоц, бэрхшээл, асуудлын гаргалгаа

Үндсэн баримтын нэр	Энэ баримт олдог. Хаанаас, яаж, хэр зэрэг бэрхшээлтэй олддогийг бичих.	Энэ баримт олдоггүй. Яагаад олдоггүй, олоход ямар бэрхшээл тохиолддогийг бичих.	Олдохгүй байгаа баримтуудыг хэрээн, яаж олох вэ? Олдох боломж байдаг болов уу? Танд ямар нэг санал байна уу?
<u>Төсвийн хүрээний мэдэгдэл</u>			
Гүйцэтгэх засаглалын төсвийн төсөл			
Батлагдсан төсөв			
Иргэдийн төсөв			
Жилийн явцын тайлангууд			
Хагас жилийн тойм			
Жилийн эцсийн тайлан			
Аудитын тайлан			

Жич: Дасгал ажиллахдаа оролцогчдыг ижил тоогоор хувааж баг болгоно. Эдгээр дасгал ажлыг хийхдээ шүүмжит эргэцүүлэн бодох (*Critical thinking*) аргыг хэрэглэх нь зүйтэй.

## ДАСГАЛ 2-2:

- Төсвийн баримт бичгүүд, тэдгээрийн хэрэглээ

Төсвийн үндсэн баримтууд	A1: Энэ баримтад ямар үндсэн мэдээллийд багтсан байх ёстой вэ?	A2: Энэ баримтыг өөрийн судалгаа, ухуулгад хэрхэн ухуулгад болох вэ?	A3: Эдгээр 8 баримт танай байгууллагын судалгаа, ухуулгад ашиглаж болох вэ?
<u>Төсвийн хүрээний мэдэгдэл</u>			
Гүйцэтгэх засаглалын төсвийн төсөл			
Батлагдсан төсөв			
Иргэдийн төсөв			
Жилийн явцын тайлангууд			
Хагас жилийн тойм			
Жилийн эцсийн тайлан			
Аудитын тайлан			

Жич: Дасгал ажиллахдаа оролцогчдыг ижил тоогоор хувааж баг болгоно. Эдгээр дасгал ажлыг хийхдээ шүүмжит эргэцүүлэн бодох (*Critical thinking*) аргыг хэрэглэх нь зүйтэй.

## Модуль хоёр: ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Нийт: 60 минут

Төсөвт оролцогч талуудыг тодруулах, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагын тухай ерөнхий ойлголт өгнө. Тухайлбал, Иргэний нийгмийн байгууллагын оролцоо, үүргийг тодотгоно.

### ХИЧЭЭЛ 3:

Хугацаа      60 минут

Агуулга	Төсвийн үйл явцад оролцогч талуудын оролцох түвшин, цар хүрээ, оролцохыг хуулиар зохицуулсан байдал, олон улсад төсвийн үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулахад баримталдаг зарчим, шилдэг туршлагуудыг танилцуулж, ИНБ-ын оролцооны ач холбогдлын талаар ойлголт өгнө.
1.	Төсөвт олон нийтийн оролцоо ба Оролцоот төсөв олон улсын туршлага
2.	Төсвийн үйл явц дах ИНБ-ын оролцоо Монголд
3.	Туршлага солилцох ярилцлага
	15 минут
	15 минут
	30 минут

### АШИГЛАХ МАТЕРИАЛ:

- Төсвийн хяналт, шинжилгээ: ИНБ-уудад зориулсан гарын авлагын 15-23 дугаар хуудаст өгөгдсөн мэдээллийг ашиглах.
- Тус гарын авлагын 40-50 дугаар хуудаст өгөгдсөн “Оролцоот төсөв” аргачлалын талаарх олон улсын туршлагуудтай танилцах.

### РРТ СЛАЙДУУД:

- Хавсралт 3-ын Слайд 1-27.

### ДАСГАЛ 3-1:

Байгууллагын танилцуулга: Байгууллагынхаа талаар бичнэ үү.

- Танай байгууллагын нэр?
- Танай байгууллага засаглалын ямар түвшин, байгууллагын үйл

ажиллагаанд анхаарч ажилладаг вэ? (улсын, салбарын, орон нутгийн, агентлаг, сангийн г.м)?

3. Танай байгууллага ямар салбарын төсвийн үйл ажиллагаанд анхаарч ажилладаг вэ? (гамшгийн төсөв, хүүхдийн эрхийн, боловсрол, ядуурал, эрүүл мэнд г.м)
4. Танай байгууллага төсвийн чиглэлээр хэр туршлагатай вэ?
5. Төсвийн үйл явцад танай байгууллагын хэдэн хүн оролцдог вэ?
6. Танай байгууллага төсвийн үйл явцад хэрхэн оролцдог вэ? (олон нийтийн сонсгол, ухуулга нөлөөлөл, судалгаа, шинжилгээ, чадавхжуулалт, сүлжээ байгууллагаар дамжуулан г.м)
7. Танай байгууллагын төсвийн үйл явцад оролцсоны үр дүн, нөлөөлөл юу байсан бэ? (бодлого, хуульд өөрчлөлт оруулсан, иргэдийн оролцоо нэмэгдсэн, төсвийн ил тод байдал сайжирсан, амьдралын түвшин дээшилсэн г.м).

### ДАСГАЛ 3-2:

Асуулгын аргаар төсвийн гүйцэтгэлийн шатны оролцогчид болон асуудлыг тодруулах

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гүйцэтгэх засаглалын ямар байгууллагад харьяалагддаг вэ?
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зорилго юу вэ?
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан ямар бүтэцтэй вэ? Орон нутагт хэдэн салбартай вэ?
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлагыг ямар хугацаатай томилдог вэ?
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ?
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хот суурин, хөдөө орон нутгийн үйл ажиллагаа хоорондоо ялгаатай юу?
7. Та хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлантай танилцаж байсан уу?
8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн жил хэзээ эхэлдэг вэ?
9. 2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан нийт төсөв хэд байсан бэ?
10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жилийн төсвийн саналыг юуг үндэслэж боловсруулдаг вэ?

11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсвийг ямар зарчмаар хэрхэн хуваилдаг вэ?
12. Та хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн шилэн дансны мэдээллийг шалгаж байсан уу?
13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн захиран зарцуулах эрх хэнд байдаг вэ?
14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төслийн зарыг хаанаас үзэж болох вэ? Жилд хэдэн удаа төслийн уралдаан шалгаруулалт явуулдаг вэ?
15. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн үйл ажиллагаа ил, нээлттэй юу?
16. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан төсвийн татаасаас гадна орлогын эх үүсвэртэй юу?
17. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгээр урт хугацааны ажлын байр хэдээр нэмэгдсэн бэ?
18. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгээр богино хугацааны ажлын байр хэдээр нэмэгдсэн бэ?
19. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үр өгөөжийн тооцоог та мэдэх үү?
20. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нийгмийн тодорхой бүлгүүдэд хэр хүрдэг талаар мэдээлэл байна уу?
21. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл зөрүүтэй эсэх талаарх мэдээллийг Та хаанаас үзэж болох вэ?

#### Ярилцлага:

Сургалтанд оролцогчдыг бүлгээр хуваана. Бүлэг тус бүр дотооддоо туршлага солилцено. Хэрэв сургалтад оролцогчид төсвийн үйл явцад оролцож байсан туршлагагүй бол Гарын авлагын аль нэг жишээний ойлгосон зүйлээсээ бусадтай хуваалцаж болно. Бүлэг тус бүр дотооддоо хуваалцсан туршлагын сургамж, бэрхшээлийг нэгтгэн, нэг төлөөлөгч нь оролцогчдод товч танилцуулга хийнэ.

**АНХААР:** Сургагч багш сэдвээс халих, хазайхаас зайлсхийж ярилцлагыг чиглүүлж зална.

#### ДАСГАЛ 3-3:

Төсвийн гүйцэтгэлд оролцогчдыг тогтоох хүснэгт ажиллах. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр жишээ татав.

АЛХАМ ҮЙЛ ЯВЦ	АЛБАН ТУШААЛ/ АГЕНТЛАГ	ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ
I Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг	УИХ	ХНХЯ саналд үндэслэнэ
II ХЭДС-ийн төсөв	ХНХЯСайд	Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагаас боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр дэмжүүлсэн санал
III Аймаг, нийслэл, дүүргийн ХЭДС-д төсөв хуваарилж батлах	ХХҮЕГ	Аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын саналыг харгалзана
IV Аймаг, нийслэл, дүүргийн ХЭДС-д төсвийн сар, улирлын хуваарийг нэгтгэн гаргаж ХНХЯ-д хүргүүлэх	ХХҮЕГ-ийн дарга, санхүү	Аймаг, нийслэл, дүүргийн хуваарь
V Төсвийн хуваарь батлах	Сагийн яам	ХЭҮЗ, ХНХЯ-ны санал
VI Төсвийн эрх нээх	СЯ, Төрийн сангийн газар	Батлагдсан хуваарийн дагуу
VII Төсвийн санхүүжилт, шилжүүлэг хийх	ХХҮЕГ дарга, сан хариуцсан нягтлан бодогч	Аймаг, нийслэл, дүүргийн албан тоот, нэхэмжлэх, баталсан төсөв, төсвийн хуваарь
VIII Хөтөлбөрийн санхүүжилт, шилжүүлэг хийх	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, нягтлан бодогч	Сонгон шалгаруулалтын материал, дүн, гэрээ
IX Хяналт	Дотоод, мэргэжлийн, төрийн аудит	Сонгон шалгаруулалтын материал, санхүүгийн тайлан, анхан шатны баримт

**АЛХАМ ҮЙЛ ЯВЦ****АЛБАН ТУШААЛ/  
АГЕНТЛАГ****ШААРДЛАГАТАЙ БАРИМТ  
БИЧИГ****Хөтөлбөрийн сонгон шалгаруулалт**

I	Хөтөлбөрөө зарлах	ХХҮГ, ХХҮХ, Хариуцсан мэргэжилтэн зарлана	Үндсэн шалгуур, нөхцөл
II	Төслийг сонгон шалгаруулах Бичиг баримтын бүрдэл Төсөл хэрэгжих байршлыг үзэх /боломжтой эсэх талаар/ Оноо өгч эрэмбэлэх Иргэн, ААН-ийг шалгаруулж тодорхойлох	Комисс	Төслийн танилцуулга, Төсөл, Санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдөл, Иргэний үнэмлэхийн хуулбар, Лавлагаанууд, Бусад лавлагаа, материал, зураг
III	Гэрээ байгуулах	ХХҮГ, ХХҮХ	Сонгон шалгаруулалтын материал, дүн

## Модуль гурав. ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

**Хугацаа: нийт 360 минут**

Энэхүү модулийн зорилго нь иргэд, ИНБ бие даан, хамтран төсвийн шинжилгээ, үнэлгээ, хяналт хийхэд шаардлагатай мэдлэг, мэдээлэл, чадвар олгох юм.

### ХИЧЭЭЛ 4:

**Хугацаа 270 минут**

Агуулга Зорилго: Энэхүү хичээлээр төсвийн шинжилгээний зорилго, ач холбогдол, төсвийн шинжилгээний төрлүүдийн талаар ойлголт, мэдлэгтэй болохоос гадна төсвийн шинжилгээний алхам, төсвийн шинжилгээ хийх удирдамж, төсвийн шинжилгээ хийх арга зүйд суралцана. Мөн сургалтад оролцогчид төсвийн шинжилгээ хийхэд оролцож байсан өөрсдийн туршлагаа бусадтай хуваалцах зорилгоор ярилцлага зохион байгуулна.

Төсвийн шинжилгээний зорилго, төрөл хэлбэр 90 минут

1. Төсвийн шинжилгээний төрөл хэлбэр, зориулалт
2. Төсвийн шинжилгээний зорилтыг тодорхойлох нь
3. Төсвийн бүтцийн шинжилгээ
4. Даасгал 4-1

Төсвийн орлого, төлөвлөлтийн шинжилгээ 90 минут

5. Төсвийн орлого бүрдэлт, хандлага
6. Улсын болон орон нутгийн төсвийн орлого бүртэлт
7. Аймгуудын төсвийн орлого бүрдэлтийн ялгаатай байдал
8. Даасгал 4-2

Төсвийн зардал санхүүжилт, гүйцэтгэлд хийх шинжилгээ 90 минут

9. Төсвийн зардлын бүтцийн шинжилгээ
10. Төсөл хөтөлбөрийн үр ашгийн шинжилгээ
11. Төсвийн зарцуулалтад худалдан авалтын үйл явцаар дамжуулан хяналт тавих
12. Даасгал 4-3-1, 4-3-2, 4-3-3, 4-3-4

### АШИГЛАХ МАТЕРИАЛ:

- Төсвийн шинжилгээ, хяналт: ИНБ-уудад зориулсан гарын авлагын 24-55 дугаар хуудаст өгөгдсөн мэдээллийг ашиглах.

РПТ СЛАЙДУУД:

- Хавсралт 4-ын Слайд 1-59.

ДАСГАЛ 4-1:

**Монгол улсын ХНХЯ-ны төсөвт хийх шинжилгээ:** Салбарын үйл ажиллагааны онцлог, нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрт эзлэх байр суурийн талаар харилцан ярилцах: Яамны үйл ажиллагааны чиг үүрэг.

**Монгол улсын төсөвт ХНХЯ-ны төсвийн эзлэх байр суурь**

МУЫН Үндсэн хууль. 16 дугаар зүйл б. Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай өдөлнэ.

4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд өд, мөнгөний тусламж авах эрхтэй;

Төрийн энэхүү хүлээсэн үүргээ ханган биелүүлэхийн тулд үйлчилгээ үзүүлэх чиг үүргээ ХНХЯ-аар дамжуулан хэрэгжүүлдэг.

Яамны үйл ажиллагааны чиг үүрэг:

**Нийгмийн хамгаалал:** нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, нийгмийн зорилтот бүлэгт үйлчилгээ үзүүлэх

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:** Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх, сургалт, судалгаа



Иргэдийн оролцоотой хяналт бүрэлдэх боломж бага, бодлогын зохицуулалтаар хангагдах ёстой

## Иргэдийн шууд оролцоотой хяналт бүрэлдэх боломжтой

### ДАСГАЛ 4-2:

**Монгол Улсын төсөв дэх НХХЯ-ны төсөв:** Төсвийн тайлагнал ямар хэлбэрээр гарч байгаа болох:

Эх сурвалж

1. Монгол улсын сангийн яам: <https://shilendans.gov.mn/>
  2. Статистик мэдээлэл: <http://1212.mn/>
  3. Бусад мэдээлэл

Төсвийн мэдээллүүд: [http://1212.mn/Stat.aspx?LIST\\_ID=976\\_L08&type=tables](http://1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L08&type=tables)

- 1) Төсвийн орлого, 2) Төсвийн зарлага, 3) Төсвийн тэнцэл, 4) Улсын өр

## УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

Шинжилгээ хийхэд анхаарах гол асуултууд

- Төсвийн орлогыг бүрдүүлж буй голлох эх үүсвэр юу болох?
- НДШ төсвийн орлого бүрдэлтэд эзлэх байр суурь?

Төсвийн орлого, төлөв байдал

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО нэр төрлийн ангиллаар, жилээр	2016	2017	2018	2019	2020	Хандлага	Хандлага
Нийт орлого ба тусlamжийн дун	5,835,044	7,958,265	10,053,628	12,040,327	10,401,976		
Тогтвортжуулалтын сан		325,680	206,987	94,597	66,243		
Нийт тэнцвэржүүслэний орлого ба тусlamжийн дун	5,835,044	7,274,862	9,225,947	10,905,511	9,421,647		
Татварын орлого	<b>4,950,950</b>	<b>6,315,132</b>	<b>8,207,105</b>	<b>9,813,196</b>	<b>8,501,795</b>		
Орлогын албан татвар	1,043,369	1,613,193	2,086,411	2,556,250	2,220,484		
Аж ахуйн иргэжийн	519,958	962,145	1,276,933	1,660,573	1,398,473		
Хүн амын	523,410	695,076	850,389	933,289	857,577		
Нийгмийн даатгалын шимтгэл	1,109,757	1,321,375	1,620,864	2,030,515	1,588,053		
Омчийн татвар	104,660	131,130	141,348	154,369	154,511		
Нэмэгдсэн ортгийн татвар	1,140,721	1,618,492	2,196,413	2,486,268	2,205,219		
Дотоодын баарыа ,үйлчилгээний албан т	558,330	734,282	898,226	1,088,304	1,053,283		
Импортын баарыны	684,254	1,031,772	1,412,056	1,633,296	1,503,778		
НОАТ -чин будаан олголт	-101,863	-147,562	-113,863	-235,332	-351,842		
Онцгой албан татвар	630,125	519,722	754,440	863,407	776,886		
Галаад худалдааны орлого	<b>328,491</b>	<b>512,351</b>	<b>682,477</b>	<b>790,178</b>	<b>740,743</b>		
Импортын баарыны	328,352	512,351	682,477	790,176	740,731		
экспортнын баарыны	138			2	12		
Бусад татвар , төлбөр, хураамж	583,060	586,483	712,089	915,853	798,828		
Татварын бус орлого	<b>884,094</b>	<b>959,730</b>	<b>1,018,842</b>	<b>1,092,315</b>	<b>919,852</b>		
Хөрөнгийн орлого	1,487	1,188	658	823	1,110		
Тусамжийн орлого	77,181	61,834	37,781	88,374	138,981		

Нэр төрөл	2016	2017	2018	2019	2020	Хандлага	Хандлага
Нийт орлого ба тусlamжийн дун	100%	100%	100%	100%	100%		
Тогтвортжуулалтын сан	<b>0%</b>	<b>4%</b>	<b>2%</b>	<b>1%</b>	<b>1%</b>		
Нийт тэнцвэржүүслэний орлого ба тусlamжийн дун	100%	91%	92%	91%	91%		
Татварын орлого	<b>85%</b>	<b>79%</b>	<b>82%</b>	<b>82%</b>	<b>82%</b>		
Орлогын албан татвар	18%	20%	21%	21%	21%		
Аж ахуйн иргэжийн	9%	12%	13%	14%	13%		
Хүн амын	9%	9%	8%	8%	8%		
Нийгмийн даатгалын шимтгэл	19%	17%	16%	17%	15%		
Омчийн татвар	2%	2%	1%	1%	1%		
Нэмэгдсэн ортгийн татвар	20%	20%	22%	21%	21%		
Онцгой албан татвар	11%	7%	8%	7%	7%		
Галаад худалдааны орлого	6%	6%	7%	7%	7%		
Бусад татвар , төлбөр, хураамж	10%	7%	7%	8%	8%		
Татварын бус орлого	<b>15%</b>	<b>12%</b>	<b>10%</b>	<b>9%</b>	<b>9%</b>		
Хөрөнгийн орлого	0%	0%	0%	0%	0%		
Тусамжийн орлого	1%	1%	0%	1%	1%		

Татварын орлогод хамаарах орлогын эх үүсвэрүүд, татварын бус орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрүүдийг тодорхойл.

Төсвийн орлогын бүтцийн шинжилгээ

Өөрт шаардлагатай мэдээллийг олж авах

Нэр төрөл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Тогтвортжуулалтын сан		325,680	206,987	94,597	66,243
Татварын орлого	<b>4,950,950</b>	<b>6,315,132</b>	<b>8,207,105</b>	<b>9,813,196</b>	<b>8,501,795</b>
НДШ	1,109,757	1,321,375	1,620,864	2,030,515	1,588,053
Татварын бус орлого	<b>884,094</b>	<b>959,730</b>	<b>1,018,842</b>	<b>1,092,315</b>	<b>919,852</b>
Нийт орлого	5,835,044	7,958,265	10,053,628	12,040,327	10,401,976
НДШ/татварын орлого	22.4%	20.9%	19.7%	20.7%	18.7%
НДШ/Нийт орлого	19.0%	16.6%	16.1%	16.9%	15.3%

Асуулт:

- Төсвийн орлого бүрдэлтэд НДШ-ийн эзлэх хувь хэмжээ хандлага ямар байгаа болох
- НДШ-ийн орлого буурч байгаа шалтгаан

Дүгнэлт:

.....  
.....  
.....

Дүгнэлтийг шалгах:

Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй харьцуулан дүгнэлтийг тодотгох

.....  
.....  
.....

УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БА ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ					
Статистик үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Орлого	5,835,043.8	7,274,861.6	9,225,947.4	10,905,510.8	9,421,647.2
Зарлага	9,495,332.9	9,017,318.6	9,222,928.5	11,661,701.3	13,960,787.5
Тэнцрэл	-3,660,289.1	-1,742,456.9	3,019.	-756,190.4	-4,539,140.3
ДНБ	23,931,342.60	28,010,710.60	32,582,629.00	37,839,225.40	37,453,275.30
Инфляцийн тувшин	1.3%	6.4%	8.1%	5.2%	2.3%
Орлого/ДНБ	24.38%	25.97%	28.32%	28.82%	25.16%
Төсвийн зарлагын есөлт		-5.0%	2.3%	26.4%	19.7%
Инфляцийн есөлт ба төсвийн зарлын есөлтийн зерүү		-127.1%	355.2%	19.7%	11.7%







ДАСГАЛ 4-3-1:

### Монгол Улсын төсвийн зардлын шинжилгээ














Шинжилгээ хийхэд анхаарах гол асуултууд

1. Төсвийн зардлын бүтцэд гарч буй өөрчлөлт, хандлага
2. Улсын төсвийн зардал дах ХНХЯ-ны төсвийн эзлэх байр суурийг тодорхойлох
3. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, эх үүсвэр

## Улсын төсвийн зарлагын төлөв байдал

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА нэр төрлийн ангиллаар, жилээр	2016	2017	2018	2019	2020	Хандлага
Нийт зарлага ба эргэж төлөгдхөн цэвэр зээл	9,495,332.88	9,017,318.60	9,222,928.50	11,661,701.20	13,960,787.50	
Ургал зардал	6,774,247.73	7,043,161.70	7,348,006.90	8,228,579.20	10,871,574.40	
Бараа, үйлчилгээний зардал	3,293,727.89	3,141,432.30	3,316,354.90	4,000,463.50	4,875,505.30	
Цалин хөлс	1,746,794.78	1,800,434.60	1,878,675.40	2,256,967.20	2,648,113.80	
Нийгмийн даатгалын шимтгэл	160,438.67	-	-	-	-	
Бараа, үйлчилгээний бусад зардал	1,386,494.44	1,340,997.70	1,437,679.50	1,743,496.30	2,227,391.50	
Зээлийн үйлчилгээний төлбөр	986,099.83	1,156,465.10	1,046,873.60	860,980.80	959,413.60	
Татаас ба бусад ургал шилжүүлэг	2,494,420.01	2,745,264.20	2,984,778.30	3,367,134.90	5,036,655.60	
Хөрөнгийн зардал	2,360,210.23	1,658,140.70	1,607,784.80	3,016,672.20	3,051,655.00	
Дотоод эх үүсвэрээр	2,360,210.20	1,658,140.70	1,607,784.80	3,016,672.20	3,051,655.00	
Хөрөнгийн оруулалт	1,576,950.90	1,559,829.50	1,510,730.50	2,835,474.60	2,888,456.10	
Их засварын зардал	129,004.70	66,992.70	84,912.60	161,645.20	143,442.70	
Геологи хайгуулын	401,482.30	-	-	-	-	
Улсын нөөц буудуулэх зардал	252,772.30	31,318.60	12,141.70	19,552.40	19,756.20	
Эргэж төлөгдхөн цэвэр зээл	521,313.60	316,016.20	267,136.80	416,449.80	37,558.10	

## Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөөв

УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА төсвийн сронхийлон захирагчар, жилээр	2016	2017	2018	2019	2020	Хандлага
Монгол Улсын Ерөнхийлгчний Тамгын газрын дарга	3,618.50	4,502.40	5,206.40	4,618.80	6,377.80	
Монгол Улсын Их Хурлын дарга	19,712.20	31,862.80	30,673.70	39,250.80	43,023.90	
Монгол Улсын Ерөнхий сайд	179,383.50	271,924.00	186,212.60	298,665.70	147,628.50	
Монгол Улсын Шалар сайд	113,693.40	110,107.30	124,730.90	141,004.00	169,666.50	
Монгол Улсын Үндсэн хуулийн цээний дарга	790.30	1,497.40	2,032.30	2,693.80	2,506.40	
Улсын дээд шүүхийн сронхийн шүүгч	3,334.80	3,395.60	3,702.10	8,462.70	3,101.10	
Шүүхийн сронхийн зөвлөлийн дарга	47,859.80	46,408.70	48,107.90	50,578.20	49,755.50	
Улсын сронхийн прокурор	17,656.00	26,715.60	28,923.20	34,176.90	38,558.50	
Үндсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	1,946.70	1,939.00	2,014.00	3,720.40	4,486.20	
Засгийн газрын хэргээлэх газрын дарга	15,246.60	20,994.70	25,132.90	55,031.70	408,611.50	
Аж үйлдвэрийн сайд	1,775.00	-	-	-	-	
